Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# НОЁН 10 ДУГААР БАГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ Д.ӨЛЗИЙМӨНХИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Үр дүнгийн үзүүлэлт | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилт 1. “Хууль тогтоомж, бодлого шийдвэрийг анхан шатанд хэрэгжүүлж, иргэд олон нийтэд сурталчлан ажиллах” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1.** Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, иргэдэд хууль эрх зүйн сургалт, зөвлөгөө өгөх /АБТодорхойлолт 1.1 дэх заалт/ | Зөвлөгөө, мэдээлэл өгсөн хүний тоогоор | 600 | 800 | Хууль тогтоомжийн бүртгэлийн санд байгаа эрх зүйн акт 48 байна. Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санг Авилга үндэсний аюулгүй байдлын талаарх хууль тогтоомж, Гэмт хэргийн тухай хууль тогтоомж, Засаг захиргаа нэгжийн хуулийн талаарх хууль тогтоомж, Нууцын тухай хууль тогтоомжууд, Татвар, нийгмийн даатгал, халамжийн талаарх хууль тогтоомж, Төрийн алба, төрийн захиргааны талаарх хууль тогтоомж, Монгол Улсын Үндсэн хуулийн талаарх хууль тогтоомжууд, Цэргийн албаны талаарх хууль тогтоомжууд гэсэн 8 төрлөөр хуулийн системчлэл хийж төрөл тус бүрээр хууль тогтоомжуудыг баяжуулан ажиллаж байна.<br>2024 оны жилийн эцсийн байдлаар иргэдэд цэрэг татлагтай холбогдуулан батлан хамгаалахын тухай хууль, цэргийн албаны тухай хуулиар 128 иргэн, хөдөлмөр халамж чиглэлээр 191, иргэний бүртгэл 67, байнгын болон түр ажлын байранд 46, банк, ББСБайгуулага 137, боловсролын байгууллагад 10, газар өмчлөл 19, гэмт хэрэг зөрчилтэй холбоотой 61 бусад төрийн байгууллагуудад хандан 143 нийт 802 иргэн зөвлөгөө мэдээлэл аван багийн Засаг даргын тодорхойлолт аван Багийн | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажлын албаар үйлчлүүлсэн байна. | | |
| | | Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулиар сургалт зохион байгуулах | Цахим Танхим | 2 | Ноёны 10 дугаар Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх аймгийн дэд хөтөлбөр, Амартайван Өвөрхангай дэд хөтөлбөр хүрээнд Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулиар сургалт зохион байгуулсан. Сургалтад 15 хэсгийн ахлагч нар хамрагдав. Сургалтаар гэр бүлд хүчирхийлэл байх байх ёсгүй, бид хүчирхийллийн хажуугаар чимээгүй өнгөрөх ёсгүй, бид нийгмийн аль давхаргад амьдарч болно гэхдээ бид хүчирхийлэлгүй гэр дүүрэн инээмсэглэлээр амьдрах хэрэгтэй талаар сургалт зохион байгуулж иргэдийн мэдлэг чадварыг дээшлүүлэв.<br>Ноёны 10 дугаар баг нь цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилтот жилийн хүрээнд ахмад настнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх, шинэчилсэн хууль, тогтоомж, төрийн үйлчилгээг цахимаар авах чадварыг эзэмшүүлэх, эрүүл мэндийн зөвлөн туслах үйлчилгээг хүргэх зорилготой нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж нийт 51 иргэн эрэгтэй 14, эмэгтэй 37 иргэн оролцсон | 01-12 | 80 |
| | | Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 2 нэр төрлийн хуулийн сургалт сурталчилгаа, гарын авлага бэлтгэн | 4 | 4-оос доошгүй | Багаас гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор 3-н төрлийн гарын авлаг бэлтгэн цэргийн зарлан авч буй 50 залуу, багийн ажлын албаар үйлчлүүлж буй 50 иргэн, Авлигын эсрэг хууль тогтоомжийг, сурталчлах өдөрлөгт 100 иргэнд тараан зөвлөгөө мэдээлэл өгөн ажилласан.<br>2024 онд e-mongolia, e-kids, Эрсдэлгүй Өвөрхангай апп, с, What 3 words апп, тоон гарын үсгийн апп-ыг сурталчилан 50 иргэний гарт утсанд нь суулган өгсөн.<br>Хором бүрээ анхааръя гэр орон сууцанд хүүхдийн аюулгүй байдал, Хариуцлагатай аав, ээжийн энгийн дүрэм, Хэрсүү гурвалжин гэж юу вэ?, эцэг, эхчүүдэд хүргэх зөвлөмжүүдийг багийн ажлын албанаас бэлтгэн Багийн ажлын албаар үйлчлүүлж буй 50 иргэнд түгээн ажилласан.<br>Аймаг, сумын ЗДТГ, Шүүх, Цагдаа, Прокурор, Нийгмийн даатгал, Татварын газар, ХХҮГазар, ЭМГазар, Статистикийн газар, Улсын | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | боловсруулсан тоогоор | | | бүртгэлийн хэлтсээс гаргасан гарын авлага материалыг багийн ажлын албаар үйлчлүүлсэн иргэдэд тайлбарлан өгч иргэдийн эрхзүйн боловсролыг дээшлүүлэн ажилласан. | | |
| 2. | **Арга хэмжээ 1.2.** Багийн иргэдийн Нийтийн хурлын бэлтгэл ажлыг хангах, шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх *1АБТодорхойлолт 1.3 дахь* | Холбогдох хууль тогтоомжийн дагуу хурлын бэлтгэл ажлыг хангасан хувиар | 100 | 100 | Арвайхээр сумын Ноён 10 дугаар багийн иргэдийн Нийтийн Хурал 2024 оны байдлаар 2 удаа хуралдсан байна. Хурлууд ЕБ-ын 5-р сургуулийн урлаг зааланд 2 удаа хуралдаж хурлын бэлтгэл ажлыг маш сайн ханган ажилласан. Хуралд нийт 157 иргэн хамрагдсан. | 01-12 | 100 |
| | | Хуралд оролцсон залуучуудын хувиар | 20 | 25-аас доошгүй хувь | 2024 оны байдлаар багийн хурал 2 удаа хуралдсан байна. Хуралд давхардсан тоогоор 157 иргэн хамрагдсан. Хуралд ирсэн иргэдийг хүйс, насны бүлгээр авч үзвэл эмэгтэй 109 иргэн буюу 69.4 хувь, эрэгтэй 48 иргэн буюу 30.6 хувь, насны бүлгээр 19-39 насны 23 иргэн буюу 14.6 хувь, 40-49 насны 42 иргэн буюу 26.8 хувь, 50-59 насны 49 иргэн буюу 31.2 хувь, 60 дээш насны 43 иргэн буюу 27.4 хувийн оролцоотой байна | 01-12 | 100 |
| 3 | **Арга хэмжээ 1.3.** Багийн Иргэдийн Нийтийн хурлын тэмдэглэл, тогтоол шийдвэрийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу хөтлөх *1АБТодорхойлолт 1.4 дэх заалт1* | Хурлаас гарсан тэмдэглэл, тогтоол шийдвэрийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулсан хувиар | 100 | 100 | Багийн иргэдийн нийтийн хурал 2024 оны байдлаар 2 удаа хуралдаж багийн иргэдийн хурлаас гарсан тогтоолууд, хурлын тэмдэглэлийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу бичин хөтөлж хугацаанд нь Арвайхээр сумын ИТХуралд уламжлан хүргэж ажилласан. Нийт БИНХурлын 7 тогтоол, 2 тэмдэглэл гарсан байна. | 01-12 | 100 |
| | **Арга хэмжээ 1.4.** Арвайхээр сумын 2025 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, | Багийн сонгуулийн насны нийт иргэдээс цаасан маягтаар | 10 | 15-аас доошгүй хувь | ОНХСангийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хийгдэх ажлын саналыг саналын хуудсаар 192 иргэн авлаа. Санал өгсөн иргэдийн тоог багийн сонгуулийн насны нийт хүн амын тоонд харьцуулахад 9.9 хувь нь саналаа өгсөн байна. | 02-05 | 100 |

211

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | хөтөлбөр, төсөл, арга хэмжээг холбогдох журмын дагуу зохион байгуулах | санал өгсөн иргэдийн хувиар | | | | | |
| | | Багийн сонгуулийн насны нийт иргэдээс цахимаар санал өгсөн иргэдийн хувиар | - | 15-аас доошгүй хувь | ОНХСангийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хийгдэх ажлын саналыг цахимаар 25 иргэн санал өгсөн байна. Санал өгсөн иргэдийн тоог багийн сонгуулийн насны нийт хүн амын тоонд харьцуулахад 1.3 хувь нь саналаа өгсөн байна.<br>ОНХСангийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хийгдэх ажлын саналыг цаасан болон цахимаар нийт 217 иргэн санал өгсөн байна.<br>Санал өгсөн иргэдийн тоог багийн сонгуулийн насны нийт хүн амын тоонд харьцуулахад 11.3 хувь нь саналаа өгсөн байна. | 02-05 | 100 |
| | | ОНХС-ын төсөл, арга хэмжээг Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтын дагуу боловсруулж, ХЗА-д хугацаанд нь бүрэн хүлээлгэж өгсөн хувиар | 100 | 100 | ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл хөтөлбөрийг эрэмбэлэх БИНХурал 5-р сарын 29-нд ЕБ-ийн 5 дугаар сургуулийн урлаг зааланд болж хуралдаанд нийт 82 иргэн оролцов.<br>Хуралдаанаар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хийгдэх арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг эрэмбэлэн санал хурааж жагсаав. Нийт 11 асуудал эрэмбэллээ.<br>ОНХСангаар хийгдэх санал, ажлуудыг ОНХС-ийн үйл ажиллагааны журмын дагуу материалыг бүрдүүлэн хугацаанд нь Арвайхээр сумын хотын захирагчийн албанд хүргүүлэн ажилласан. | 05-06 | 100 |
| 5. | **Арга хэмжээ 1.5.** Хэсгийн ахлагчдын ажлын тайлан, мэдээг сар бүр хүлээн авч, улирал бүрээр нэгтгэн ИТХ-д хүргүүлэх | Хүргүүлсэн тайлангийн тоогоор | 4 | 4 | Ноёны 10 дугаар баг нь 18 хэсгийн ахлагч ажиллаж байна. Сар бүрийн 5,20-нд хуримтлалын хурал хийж хэвшсэн.<br>Сар бүрийн 5-нд багийн ажлын албанаас мэдээ мэдээлэл авч иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулж, сар бүрийн 20-нд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан багийн ажлын албанд хүргүүлэн ажиллаж байна.<br>Хэсгийн ахлагч нарын хийсэн ажлын тайланг нэгтгэн улирал бүр Арвайхээр сумын ЗДТГазарт хүргүүлэн ажиллаж хэвшсэн. | 01-12 | 100 |
| | **Арга хэмжээ 1.6.** | Бүртгэлд | | | 2024 оны Цэргийн бүртгэл 2024 оны 1-р сарын 08-17 хооронд багийн | | |

212

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6. | Багийн хэмжээнд цэргийн бүртгэлийг зохион байгуулах, мэдээ, тайланг тогтоосон хугацаанд хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгөх /АБТодорхойлолт 1.4 дэх заалт/ | хамрагдсан хувиар | 100 | 100 | нэгдсэн төвийн зааланд болсон багийн 18-50 насны 745 иргэнээс өөрийн биеэр ирж бүртгүүлсэн 560 иргэн, e-mongolia цахимаар 64 иргэн цэргийн бүртгэлд хамрагдаж хамрагдалтын хувь 100%. Үүнээс бэлтгэл офицер 4, бэлтгэл ахлагч 8, түрүүч, байлдагч 226, 2-р зэргийн бэлтгэл үүрэгтэн нийт 393, цэрэгжсэн байгууллагад ажилтан 68, тайван цагт цэргийн албанд тэнцэхгүй 37, цэргийн алба хааж байгаа 5 залуу, ял эдэлж байгаа 4 иргэн байна. | 01-01 | 100 |
| | | Хүргүүлсэн судалгаа, тайлангийн хувиар | 100 | 100 | 2024 оны цэргийн бүртгэлийн судалгааг маягт загварын дагуу хугацаанд Сумын хууль эрх зүйн мэргэжилтэнд хүргүүлэн ажилласан. | 01-01 | 100 |
| 7. | **Арга хэмжээ 1.7.** Сумын дайчилгааны төлөвлөгөө, орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө, орон нутгийн цэргийн отрядын хүн, техникийн оногдуулалтыг хийж бэлтгэл үүрэгтний бэлэн байдлыг хангах | Төлөвлөгөөний дагуу оногдуулалт хийсэн хувиар | 100 | 100 | Аймгийн дайчилгааны бэлэн байдлын судалгаанд бэлтгэл офицер 3, бэлтгэл ахлагч 5, байлдагч, түрүүч 69, цэргийн мэргэжилтэй эмэгтэйчүүд 3, тээврийн хэрэгсэл 11 тус бүрийн судалгааг хүснэгт зааврын дагуу гарган баяжилт хийн ажилласан.<br>Арвайхээр сумын томилгоот нэгж бие бүрэлдэхүүнд байлдагч, түрүүч 48, 2 дугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн 69, 10 мотоцикл, 2 ачааны машин, 2 суудлын машины тус бүрийн судалгааг хүснэгт зааврын дагуу гарган оногдуулалтын баяжилт хийн ажилласан.<br>Арвайхээр сумын отрядын бүрэлдэхүүнд байлдагч, түрүүч 9, суудлын 4*4 2 авто машины судалгааг тус бүр гарган оногдуулалтын баяжилт хийн ажилласан. | 01-02 | 100 |
| | | Гаргасан судалгааны тоогоор | 1 | 1 | Цэргийн тоо бүртгэлээр 18 төрлийн судалгааг маягт загварын дагуу гарган Сумын хууль эрхзүй асуудал хариуцсан мэргэжилтэнд хүргүүлэн ажилласан. | 01-03 | 100 |
| 8. | **Арга хэмжээ 1.8.** Багийн хэмжээнд цэрэг татлагын ажлыг зохион байгуулах /АБТодорхойлолт 1.4 дэх заалт/ | Иргэдийн хамрагдалтын хувиар | 98 | 100 | Арвайхээр сумын цэрэг татлаг 2024 оны 4 дүгээр сарын 16-17 өдрүүдэд болж тус багаас 107 цэргийн насны залуучууд зарлан дуудах хуудас авч өөрийн биеэр 82 залуу, 1998 оны мөнгөн төлбөрөөс чөлөөлөгдөх 19 залуу 2-н оюутны бичиг баримт бүрдүүлж нийт 101 залуу цэрэг татлагын комиссоор оров. Комиссын үзлэгээр хилийн цэргийн 131-р ангид 4 цэрэг, тэнцэн цэргийн алба хааж байна.<br>Арвайхээр сумын 2-р ээлжийн цэрэг татлагаар 2006 оны 5-р сараас хойш төрсөн 18, хавар цэрэг татлагын үеэр шалгалт шүүлгэтэй байсан 2 оюутан нийт 20 залуу цэрэг татлагаар орсон. Улаанбаатар хот ЗХ-ний 32-р анги 1, ЗХ-ний 326-р анги 1, Дотоодын цэргийн 805-р анги 1, Өмнөговь аймгийн ЗХ-ний 167-р анги 1, Аймгийн 256-р анги 1 нийт 5 | 04-05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | цэрэг цэргийн алба хааж байна. | | |
| | | Цэргийн алба хааж буй иргэдийн ар гэрт олгох дэмжлэг, туслалцаанд хамруулсан өрхийн тоогоор | - | Шаардлагатай өрхийг хамруулсан байдлаар | Арвайхээр сумын 1-р ээлжийн цэрэг татлагаар Хилийн 0131-р ангид цэргийн алба хааж буй Ц.Отгонмөнх, Зэвсэгт хүний 326-р ангид алба хааж буй П.Санжаадамбын ар гэрт малын ногоон тэжээл, хивэгний тусалцаа дэмжлэг үзүүлсэн. | 01-12 | |
| **Зорилт 2. "Багийн өрх, хүн амын статистикийн мэдээллийг зохих журмын дагуу нийтэд мэдээлж, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангаж, удирдлагыг мэдээллээр хангах, тайлагнах" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 2.1.** Хүн ам, өрхийн мэдээллийн санг үнэн зөв хөтөлж, баяжилтыг тогтмол хийж, төрийн байгууллага, хэрэглэгчдийг мэдээллээр хангаж ажилласан байх *ABTодорхойлолт 2.1 дэх заалт/* | ХАӨМС-ын програмын алдааны тоогоор | - | Алдаагүй байх | 2024 оны жилийн эцсийн байдлаар 180 иргэн шилжиж явсан бол 139 иргэн шилжин ирж засаг захиргааны шилжилт хөдөлгөөн хийгдсэн байна. ХАӨМС-ийн программд нас барсан 21, шинэ төрсөн 46 хүүхэд, шилжиж ирсэн явсан иргэдийг бүртгэн өөрийн цахим сан, программд баяжилт хийн ажиллаж байна.<br>Өрх, хүн амын төрөлт, нас баралт, шилжилт хөдөлгөөний мэдээллийг цаг тухай бүрд оруулж, өрх хүн амын өөрчлөлтийг мэдээллийн санд оруулахдаа дагалдах үзүүлэлт бүрд баяжилт хийн оршин суугаа бүртгэл, боловсролын түвшин, хөгжлийн бэрхшээлтэй эсэх, гэрлэлтийн байдал, хөдөлмөр эрхлэлт, орлогын хэлбэр, нийгмийн халамжит хамрагдсан эсэх, цэргийн алба хаасан эсэх, утасны дугаар, өрхийн үзүүлэлт, хаяг, өрхийн байршлын зурагт тэмдэглэл хийх, өрх, хүн бүрээр ирсэн алдааг засаж тогтмол баяжилт хийн ажиллаж байна. | 01-12 | 100 |
| 2. | **Арга хэмжээ 2.2.** Багт шинээр баригдсан орон сууцны тооллогын мэдээг ОС1, ОС3 маягтаар гаргаж өгөх *ABTодорхойлолт 2.1 дэх заалт/* | Шинээр баригдсан орон сууцны мэдээллийг маягтын дагуу гаргаж өгсөн тоогоор | - | Шинээр баригдсан орон сууцны тоогоор | Багт ашиглалтад орсон сууцны тусдаа байшин, бие даасан тохилог сууц 9 шинээр барьж улсын бүртгэлийн гэрчилгээ гаргуулах албан тоот аван багийн ажлын албаар үйлчлүүлсэн байна.<br>Баг өөрийн нутаг дэвсгэрт 9 шинээр ашиглалтад орсон сууцны тусдаа байшин, бие даасан тохилог сууцын мэдээг үндэсний статистикийн хорооны гаргасан загвар маягтын дагуу гарган Аймгийн статистикийн хэлтэс хагас, бүтэн жилээр хүргүүлэн ажиллаж хэвшсэн. | 01-12 | 100 |
| 3. | **Арга хэмжээ 2.3.**Залуучуудын | Гаргасан судалгаан | | 1 | Багийн 15-34 насны 1064 залуучууд байна. Эрэгтэй 526, эмэгтэй 538 байна. 57 үзүүлэлтийн дагуу судалгааг гарган цахим сан үүсгэн баяжилт | 01-03 | ~~80~~ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | суурь судалгаанд баяжилт хийж шинэчилж гаргах */АБТодорхойлолт 2.3 дахь заалт/* | ы тоогоор | 1 | | хийн ажиллаж байна. | | 100 |
| 4. | **Арга хэмжээ 2.4.** Багт зохион байгуулсан ажил, арга хэмжээ болон бусад мэдээллийг олон нийтэд цахим хуудсанд сурталчлах */АЗД-аас СЗД-тай 2023 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний 1.2.1, АБТодорхойлолт 3.3 дахь заалт/* | Багийн цахим хуудсаар дамжуулан үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээлэл боловсруулж иргэдэд нээлттэй сурталчилгаа хийсэн тоогоор | 12 | 12 | Багийн Noyon Arvaikheer facebook хаягт багийн иргэдийн хурлын зар, бүх нийтийн цэвэрлэгээний зар, Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургуулилтын зар, Цэрэг татлага, цэрэг бүртгэлийн зар, ОНХСангын тухай ойлголтын талаарх мэдээлэл, зар, нохойгоо бүү тавь мэдээлэл, постер боловсруулж иргэдэд мэдээлэл өгөн ажилласан.<br>Багийн facebook хаягыг ашиглан өдөр бүр төрийн байгууллагуудаас гарсан мэдээллийг олон нийтэд мэдээллэн ажиллаж байна. | 01-12 | 100 |
| 5. | **Арга хэмжээ 2.5.** Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн насны хүүхдүүдийг боловсролын үйлчилгээнд хамруулах, хамран сургалтыг нэмэгдүүлэх, Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадаагүй иргэдийг дүйцсэн хөтөлбөрт хамруулж, боловсрол эзэмшүүлэх | Сургуулийн насны хүүхдийн хамран сургалтын хувиар | 100 | 100 | 2024 онд 1 дүгээр ангид элсэн суралцах 79 хүүхдийн судалгааг ирсэн маягт загварын дагуу гарган Сумын нийгмийн бодлогын мэргэжилтэн Т.Дэлгэрмаад хугацаанд хүргүүлэн ажилласан. 10-р багт сургууль завсардсан хүүхэд байхгүй. | 09-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Цэцэрлэгийн насны хүүхдийн хамран сургалтын хувиар | 75 | 85 | Цэцэрлэгийн насны 2019 оны 5 настай бэлтгэл ангийн 84, 2020 оны 79, 2021 оны 73, 2022 оны 86 нийт 323 хүүхэд байна. Хамрагдалтын хувь 96.6<br>Цэцэрлэгт бүртгэлгүй, явдаггүй 11 хүүхэд байна. 2019 оны 5 настай 1 хүүхэд, 2021 оны 3 настай 3 хүүхэд, 2022 оны 2 настай 6 хүүхдийн судалгаа ирсэн маягт загварын дагуу гарган Сумын нийгмийн бодлогын мэргэжилтэн Т.Дэлгэрмаад хугацаанд хүргүүлэн ажилласан.<br>2024 оны 12-р сарын 1-ээс 15-р цэцэрлэг шинээр ашиглалтад орж байгаа цэцэрлэгт хамрагдаагүй 11 хүүхдийн эцэг, эхтэй нь холбогдож хүүхдээ цэцэрлэгт оруулах зар мэдээллийг өгөн ажилласан. | 09-12 | 100 |
| 6. | **Арга хэмжээ 2.6.** Агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллогыг явуулж 3-15кВт эх үүсвэрийн мэдээллийг программд бүрэн оруулах | Судалгааг шинэчилж, хугацаанд нь алдаагүй программд оруулсан хувиар | 100 | 100 | Агаар бохирдуулагч эх үүсвэрийн мэдээллийн санд 3-15 квт хүчин чадалтай 874 өрх, усан халаалтын 15-100 квт чадалтай зуухтай 2 нийт 876 өрхийн судалгааг өгөгдсөн маяг загварын дагуу гарган Аймгийн цаг уурын газрын мэргэжилтэн Б.Ичинхорлоод хугацаанд нь хүргүүлэн ажилласан. | 01-02 | 100 |
| Зорилт 3. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 3.1.** Жилийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон бусад хөтөлбөр төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, батлуулах | Төлөвлөгөөний тоо | 1 | 1 | Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Арвайхээр сумын ЗДТГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон бусад хөтөлбөр төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулсан. | 01-03 | 100 |
| 2. | **Арга хэмжээ 3.2.** Хугацаатай үүрэг даалгавар, тайлан мэдээ, албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлэх, тэдгээрийг албан | Тухай бүр хугацаанд нь хүргүүлсэн хувиар | 100 | 100 | 2024 оны жилийн эцсийн байдлаар ирсэн бичгийн баримт бичгийн бүртгэлд 65, явсан баримт бичгийн бүртгэлд 167 баримт бичиг бүртгэгдсэн байна.<br>Аймаг, сумын ЗДТГазар болон бусад байгууллагаас ирсэн 65 баримт бичгээс 58 хариутай бичигт хяналт бүртгэлийн карт нээн хариуг хугацаанд нь хүргүүлэн ажилласан. | 01-12 | 100 |
| | | Албан | | | Багаас багийн иргэдийн хурлын 7 тогтоол, 2 тэмдэглэл, А-5 167 албан | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, баримт бичгийн стандартын дагуу боловсруулах */АЗД-аас СЗД-тай 2023 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний 1.1.8, АБТодорхойлолт 4.3 дахь заалт/* | бичгийн боловсруулалтад ЗГ-ын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Стандарт хэмжилзүйн газрын даргын 2021 оны С/30 дугаар тушаалаар батлагдсан MNS5140-1:2021 баримт бичгийн стандартыг мөрдөж ажилласан хувиар | 100 | 100 | тоотыг албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, баримт бичгийн стандартын дагуу боловсруулан ажилласан. | 01-12 | 100 |
| 3. | **Арга хэмжээ 3.3.** Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг хугацаанд нь дээд шатны байгууллагад уламжилж, бүртгэлийн дэвтэрт бүртгэсэн байх, холбогдох мэдээ тайланг хугацаанд | Алдарт эхийн одон, төрийн дээд одон медалиар шагнуулах иргэдийн материал, өргөдөл, гомдлыг | 100 | 100 | “Алдарт эх”-ийн 1 дүгээр одон 1 эх, 2 дугаар зэргийн одон авах эрх үүссэн 15 эхийн судалгааг гаргаж, зар мэдээг хүргэж холбогдох материалуудыг бүрдүүлэн авч сумын ЗДТГазрын соёл, аялал жуулчлалын мэргэжилтэн Мөнгөнцэцэгт хугацаанд нь хүргүүлэн ажилласан.<br>2024.06.01-ний өдөр аймгийн ХДТеатрд 13 эхэд аймаг сумын удирдлагууд Алдарт эх одонг гардуулсан.<br>Төрийн дээд шагналд Хөдөлмөрийн гавьяаны улаан тугын одонд 1, Алтангадас одонд 1 иргэн, Хөдөлмөрийн хүндэт медальд 1 иргэн, нийт 3 иргэний материалыг бүрдүүлэн сумын ЗДТГазарт уламжлан ажилласан. | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нь өгөх */АЗД-аас СЗД-тай 2023 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний 1.1.9, АБТодорхойлолт 4.3 дахь заалт/* | хуульд заасан хугацаанд шуурхай, хүнд суртал, чирэгдэлгүй уламжилж, хариу өгсөн хувиар | | | | | |
| 4. | **Арга хэмжээ 3.4.** Аймаг, сумын удирдлагаас ирүүлсэн тогтоол, захирамжийг хяналтад авах, үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах */АБТодорхойлолт 4.3 дахь заалт/* | Тогтоол, шийдвэрийг хяналтад авч биелэлтийг тайлагнасан тоогоор | - | - | ЗГ-ын 2023 оны Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай 119-р тогтоол, Аюулгүй иргэн Амар тайван Өвөрхангай" дэд хөтөлбөр, сумын Цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилтот жилийн тогтоол шийдвэрийг хяналтад аван хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 01-12 | 90 |
| | | "Амар тайван Өвөрхангай" дэд хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар *АЗДҮАХ-ийн 3.3.3.1 дэх заалт* | 95 | 100 | Амар тайван Өвөрхангай хөтөлбөрийн хүрээнд 1 зорилт 3 арга хэмжээний төлөвлөгөөг гарган багийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Төллөвгөөний зорилтууд бүрэн хэрэгжсэн.<br>Багийн нутаг дэвсгэрт эргүүл хяналтыг 7 хоногт 1 удаа тогтмол хийж үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний дэлгүүр, үйлчилгээний газруудад аймаг, сумын Засаг даргын захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин, мэдээ сурталчилгаа хийн ажиллаж хэвшсэн.<br>Дэлхийн тамхигүй өдрийг угтан багийн ажлын алба, хэсгийн ахлагч нар, иргэд, Нарны дөш ӨЭМТөвтэй хамтран өглөө 07-09 цагийн хооронд МТ шатахуун түгээх станцын уулзвараас Ноён хүнсний дэлгүүр хүртэл 2.5 км авто зам дагуу тамхины иш түүлгэж тамхины эсрэг дуу хоолойгоо өргөж, тамхинаас татгалзах олон нийтэд нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан.<br>Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдрөөр 25 иргэд, хүүхдүүдэд гарын авлага тарааж зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. | 01-12 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5. | **Арга хэмжээ 3.5.** Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийг хууль тогтоомж, заавар журмын дагуу хөтлөн явуулж, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримтыг бүрдүүлж архивлах. */АБТодорхойлолт 4.3 дахь заалт/* | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримтыг бүрэн хөтлөх. Архивын баримтыг бүрэн бүрдэлтэй нь хугацаанд байгууллагын архивд хүлээлгэн өгсөн тоогоор | 5 | 5 | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивлах баримтуудыг цэгцлэн 2024 оны 03-р сарны 30-ны өдөр 5 хавтас бүхий нэгж үүсгэн архив бичиг хэргийн эрхлэгчид хугацаанд хүлээлгэн өгсөн. | 01-03 | 100 |
| 6. | **Арга хэмжээ 3.6.** Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллах | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 95 | 100 | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө 1 зорилт 7-н хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган багийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 7 зорилтын хэрэгжилтийн бүрэн хэрэгжсэн.<br>Багийн нутаг дэвсгэрт эргүүл хяналтыг 7 хоногт 1 удаа тогтмол хийж үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний дэлгүүр, үйлчилгээний газруудад аймаг, сумын Засаг даргын захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин, мэдээ сурталчилгаа хийн ажиллаж хэвшсэн.<br>Арвайхээр сумын 10-р багийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний дэлгүүрүүдэд хүнсний аюулгүй байдал, стандарт хэмжилзүйн газраас жижиглэн худалдаа түүний үйлчилгээний стандартын тухай зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Уг сургалтанд 10 хүнсний дэлгүүрийн худалдагч оролцсон. “<br>ОДОО Л БОЛЬЁ” арга хэмжээ нь иргэн, аж ахуй нэгж байгууллагад архи согтууруулах ундааны зохисгүй хэрэглээ, түүний хор хөнөөлийн талаар ойлгуулах, урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн “Одоо л больё” нэгдсэн арга хэмжээг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 43 дугаар зарлигийн хүрээнд Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс зохион байгуулсан. Тус | 01-12 | 90 |

019

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | арга хэмжээнд 9 эрэгтэй, 23 эмэгтэй нийт 32 иргэн оролцсон.<br>Хүний эрхийн коммисийн гишүүд Арвайхээр сумын иргэдэд хүний эрхийн хууль эрхзүйн ойлголт, төрийн байгууллагын чиг үүрэг гэх мэдээлэл чиглэлээр мэдээлэл өгч ажилласан. Тус сургалтанд 10 иргэн оролцсон.<br>Дэлхийн тамхигүй өдрийг угтан багийн ажлын алба, хэсгийн ахлагч нар, иргэд, Нарны дөш ӨЭМТөвтэй хамтран өглөө 07-09 цагийн хооронд МТ шатахуун түгээх станцын уулзвараас Ноён хүнсний дэлгүүр хүртэл 2.5 км авто зам дагуу тамхины иш түүлгэж тамхины эсрэг дуу хоолойгоо өргөж, тамхинаас татгалзах олон нийтэд нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан.<br>Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдрөөр 25 иргэд, хүүхдүүдэд гарын авлага тарааж зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.<br>“Эх үрсийн баяр”-ыг угтан хүүхдийн тоглоомын талбайг цэвэрлэх ажлыг зохион байгуулдаг Тус ажлыг хийхэд “Бэрс финанс” ББСБ-ын албан хаагчид, 2-р сургуулийн ахлах ангийн 10 хүүхэд, багийн ажлын алба хамтран ажлыг гүйцэтгэсэн. | | |
| 7. | **Арга хэмжээ 3.7.** Аймаг, сумын зорилтот жилийн ажлын хүрээнд багт хийгдэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, үр дүнг тооцох | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 96 | 100 | Сумын “Цахим шилжилтийг эрчимжүүлэх” зорилтот жилийн хүрээнд баг 3 бүлэг 11 зорилт арга хэмжээний төлөвлөгөөг багийн Засаг даргаар батлуулан ажиллаж байна.<br>“Цахим шилжилтийг эрчимжүүлэх” зорилтот жилийн хүрээнд Иргэдийн цахим ур чадварыг хөгжүүлэх анхан шатны сургалтад хамрагдаж сурагч багшаар бэлтгэгдсэн.<br>Иргэд www.e-mongolia.mn веб портал болон “E-Mongolia” гар утасны аппликейшн ашиглаж аль нэг төрийн байгууллагыг зорьж очилгүйгээр, өөрт хэрэгтэй төрийн үйлчилгээг гэрээсээ эсвэл ажил дээрээсээ ямар ч цаг үед авч болох боломжийг "E-Mongolia" олгож байх талаар иргэдэд мэдээллэн ажиллаж байна.<br>Багт EMongolia цахим системийг ашиглан 64 иргэн цэргийн бүртгэлээр бүртгүүлсэн, 53 иргэн EMongolia цахим системийг ашиглан ОНХСанд цахимааар саналаа өгсөн байна.<br>2024 оны 3-р сард малчин өрхэд Засгийн газар, Улсын онцгой комиссоос хөнгөлөлттэй үнээр өвс тэжээл өгч Багийн нэгдсэн төвийн зааланд сургалт зохион байгуулсан.Сургалтад багийн 45 малчин оролцож Эрсдэлгүй Өвөрхангай апп-ыг сурталчилж, What 3 words апп-ыг сурталчлан иргэдэд ашиглалтыг заан өгч ажилласан.<br>Тоон гарын үсэг хэрэглээнд нэвтэрч эхэлснээр цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хоорондоо цахим хэлбэрээр гэрээ хэлцэл хийх, албан байгууллагад өргөдөл, гомдол гаргах, банк санхүү, даатгалын байгууллагуудтай цахимаар харилцах гэх мэт олон боломжууд нээгдэж ач холбогдолтой талаар иргэдэд тайлбарлан өгөн ажиллаж байна.<br>2024 онд шилжиж ирсэн 18-аас дээш насны 32 иргэнийг Арвайхээр сум | 01-12 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хариуцсан улсын бүртгэгч рүү явуулж тоон гарын үсгийг авхуулан хамтран ажилласан .<br>Ноёны 10 дугаар баг нь цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилтот жилийн хүрээнд ахмад настнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх, шинэчилсэн хууль, тогтоомж, төрийн үйлчилгээг цахимаар авах чадварыг эзэмшүүлэх, эрүүл мэндийн зөвлөн туслах үйлчилгээг хүргэх зорилготой нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж нийт 51 иргэн эрэгтэй 14, эмэгтэй 37 иргэн оролцсон.<br>Багийн Noyon Arvaikheer facebook хаяг, 10-р багийн иргэд чат группд Зорилтот жилийн ажлын хүрээнд Цахим хөгжлийн яамаас гарсан контент, Аймгийн ЗДТГазар, Сумын ЗДТГазар, Төрийн цахим үйлчилгээний зохицуулатын газраас гарсан конттент, шторк, цахим орчинд сурталчлан ажиллаж байна. | | |
| 8. | **Арга хэмжээ 3.8.** Төрийн байгууллагын веб сайтад тавигдах мэдээг улирал бүр гарган, холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх, ажлын жагсаалтыг сар бүр хүргүүлэх | Веб сайтад байршуулах мэдээг гарган хүргүүлсэн тоо | 4 | 4 | Веб сайтын мэдээг улирал бүр Noyon Arvaikheer группээс arvaikheer.mn вэб сайтад байршуулж, иргэдэд үйл ажиллагаагаа нээлттэй сурталчилан ажиллаж байна. | 01-12 | 100 |
| | | Сар бүрийн ажлын жагсаалтыг хугацаанд нь хүргүүлсэн тоо | 12 | 12 | Сар бүр хийсэн ажлын тайланг сар бүрийн 23-ний дотор Сумын хууль эрхзүйн мэргэжилтэд цахимаар өгч хэвшсэн. | 01-12 | 100 |
| 9. | **Арга хэмжээ 3.9.** Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, байгууллагад мөрдөгдөж буй | Ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчилгүй бүртгэгдээ | - | Ёс зүйн зөрчилгүй ажилласан | Багийн ажлын албаны Зохион байгуулагч нь Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлээр Туслах түшмэл ТЗ-10 албан тушаалд ангилагддаг.<br>Төрийн ажил, үйлчилгээнд улс төржсөн, намчирхсан байдал гаргалгүй төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйлийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, хувь хүний ёс зүй, харилцааг мөрдөн ажиллаж байна. | 01-12 | 100 |

221

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дүрэм журам, төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг мөрдөж, ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчилгүй ажилласан байх | гүй ажилласан байх Зөрчлийн тоогоор | | байх | Төрийн албан хаагчийн хувьд иргэдтэй зөв боловсон харьцаж ёс зүйн талаар гомдол, алдаа дутагдал гаргалгүй ажиллаж байна.<br>Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” байгууллагын Дотоод журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Төрийн албан хаагчийн хувийн хэрэгт ёс зүйн зөрчлийн тэмдэглэл хийгдээгүй.<br>Ажлын цагийг зөв зохистой ашиглан гомдол зөрчил гаргалгүй ажиллаж байна.<br>Шалтгаангүйгээр ажил таслах, хоцрох зөрчил гаргаагүй.<br>Ажлын байранд болон ажлын цагаар согтууруулах ундаа хэрэглэсэн зөрчил гаргаагүй.<br>Сахилгын шийтгэл авагдаагүй. | | |
| 10. | **Арга хэмжээ 3.10.** Байгууллагаас зохион байгуулсан цаг үеийн холбогдолтой, нэмэлт үйл ажиллагаанд идэвхтэй оролцох. */АБТодорхойлолт 3.4 дэх заалт/* | Оролцсон арга хэмжээний тоогоор | - | Арга хэмжээний тоо | Байгууллагаас зохион байгуулсан мод бут тарих, мөсний баяр, цагаан сарын золголт, гар бөмбөгийн тэмцээн, өглөөний цайны уулзалт арга хэмжээнд идэвхтэй оролцсон. | 01-12 | 100 |
| Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт: | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 1.** Сонгуулийн хэсгийн хорооны ажилд туслалцаа үзүүлж ажилласан байх | Сонгуулийн хэсгийн хороонд орж ажиллах | | | 2024 оны УИХ-ын ээлжилт сонгууль, Орон нутгийн аймаг сумын ИТХурын ээлжит сонгуульд Арвайхээр сумын сонгуулийн 10 дугаар хэсгийн хороонд гишүүнээр орон ажилласан. | 05-06 | 100 |
| Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт арга хэмжээ | | | | | | | |
| 2.1 | Худалдан авах ажиллагааны А3 сертификат олгох сургалтад хамрагдах. | А3 сертификат авсан байна | | | Худалдан авах ажиллагааны А3 сертификат олгох сургалтад хамрагдан шалгалтад тэнцэн А3 сертификат авсан. | 01-12 | 100 |
| 2.2 | Компьютерийн өргөн хэрэглээний | Компьютерийн өргөн | | | “Цахим шилжилтийг эрчимжүүлэх” зорилтот жилийн хүрээнд “Иргэдийг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | программ хангамж, цахим хөгжүүлэлт чиглэлээр сургалтад хамрагдах. | хэрэглээний программ хангамж, цахим хөгжүүлэлт чиглэлээр 5-7 хоногийн хугацаатай 1 удаагийн сургалтад хамрагдаж сертификат авсан байна. | | | цахим ур чадварыг хөгжүүлэх анхан шатны сургалтад хамрагдаж сургагч багшаар бэлтгэгдсэн.<br>Төрийн албан хаагчийг үндэсний бичиг мэдлэг чадварыг сайжруулах зорилгоор зарласан “Хүмүүн бичигтэн” аяны хүрээнд үндэсний бичгийн сургалтад хамрагдаж монгол бичгийн анхан шатны мэдлэгтэй болсон. | 01-03 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ Д.ӨЛЗИЙМӨНХ (..........................) 2024.11.22

0223